



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 05 өдөр

Дугаар /Мөн/

Мандалговь

Г Хөрөнгө гаргах тухай 7

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1, Төсвийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолын 08 дугаар хавсралт, Аймгийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/439 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэний эрх зүйн боловсрол” аймгийн хөтөлбөр”-ийн 7 дугаар зүйлийн 7.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 06 дугаар 30-ны өдрийн 10 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Нэг. “Хууль зүйн мэдээлэл” төслийг хавсралтаар баталсугай.

Хоёр. “Хууль зүйн мэдээлэл” төслийг 3.000.000 /Гурван сая/ төгрөгөөр хөтөлбөр, арга хэмжээний зардлаас санхүүжүүлсүгэй.

Гурав. Дээрх төслийг 2017 оны 08 дугаар сарын 15-ны дотор сонгон шалгаруулахыг Хууль, эрх зүйн хэлтэс /Б.Түвшинбаяр/-т даалгасугай.

Дөрөв. Шалгарсан төслийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж зохих журмын дагуу зохион байгуулахыг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Хууль, эрх зүйн хэлтэс /Б.Түвшинбаяр/-т, ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200095